

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/29 дүгээр зүйл:**

“29 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх

29.1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

29.2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь хуульд заасны дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан журмыг баримтална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

#### **1/229 дүгээр зүйлийн 229.4 дэх хэсэг:**

“229.4.Улсын хилээр тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Гаалийн тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/229 дүгээр зүйлийн 229.2 дахь хэсэг:**

“229.2.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татваргүйгээр 30 хоногийн хугацаагаар түр нэвтрүүлнэ.”

#### **2/278 дугаар зүйл:**

“278 дугаар зүйл.Биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх

278.1.Улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг:**

“41.9.Улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.”

#### **2/41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг:**

“41.2.Тусгай хэрэгслийн жагсаалт, бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэрэглэх стандартыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**3 дугаар зүйл.** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.4-т “биеийн хүч хамгаалах урлагын зэвсэггүйгээр тулалдах мэх” гэснийг, 41.10 дугаар зүйлийн “хэрэгсэл” гэсний дараа “мэх” гэснийг, 41.11 дүгээр зүйлд “хэрэгсэл” гэсний дараа “мэх” гэснийг “ биеийн хүч” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь заалт:**

“24.1.8.албан үүргээ гүйцэтгэх явцдаа биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх;”

#### **2/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:**

“24.2.Авлигатай тэмцэх газрын эрх бүхий алба хаагч нь хуульд заасны дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан журмыг баримтална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“22 дугаар зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх**

22.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.”

**2 дугаар зүйл.**Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:**

“3/хүчирхийлэл, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчлах, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц үйлдэл хийх, түүнд турхирах.”

#### **2/8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Өлсгөлөн зарласан этгээдэд эмнэлгийн үйлчилгээг албадан үзүүлэх зааврыг Улсын ерөнхий прокурор, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

#### **3/11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 9 дэх заалт:**

“9/жагсаал, цуглааныг өдрийн цагаар зохион байгуулах.”

**2 дугаар зүйл.** Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “халдлагаас хамгаалах” гэсний дараа “, урьдчилан сэргийлэх” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### **ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Захиргааны хариуцлагын тухай” гэснийг “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** усгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“32 дугаар зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх**

1.Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

**СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН  
ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“37 дугаар зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх**

37.1.Хорих байрны хамгаалалтын болон дэг журам сахиулах үүрэг бүхий ажилтан Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.”

**2 дугаар зүйл.**Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 38, 39, 40, 41 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### **ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

#### **1/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:**

“6.4. “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.10 дахь заалтад заасныг.”

#### **2/8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэг:**

“8.9. Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад энэ хуулийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8-д заасныг дагаж мөрдөнө.”

#### **3/9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсэг:**

“9.2. Авлигатай тэмцэх газар, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тахарын алба нь Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулна.

9.3. Авлигатай тэмцэх газар, тагнуул, цагдаагийн байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулна.”

#### **4/11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэг:**

“11.9. Цагдаа, шүүхийн гийдвэр гүйцэтгэх болон авлигатай тэмцэх байгууллага нь гүйцэтгэх ажилтан, туслах ажилтнаар ажиллуулах хүнийг шилж слнгох зорилгоор гүйцэтгэх ажил явуулж болно.”

**2 дугаар зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль,” гэсний дараа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:**

“6.2.“Эрэн сурвалжлах нууц ажиллагаа” гэж Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг;”

### **2/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:**

“9.1.Тагнуулын байгууллага нь гадаад тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, заналаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулна.”

### **3/11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсэг:**

“11.2.Авлигатай тэмцэх газар, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тахарын алба нь Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулна.

11.3.Авлигатай тэмцэх газар, тагнуул, цагдаагийн байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулна.”

### **4/12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4 дэх заалт:**

“12.1.3.энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т зааснаас бусад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах мөрдөн шалгах нууц ажиллагаа;

12.1.4.энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т зааснаас бусад Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах эрэн сурвалжлах нууц ажиллагаа.”

### **5/23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг:**

“23.3.Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3-т заасан байгууллагын явуулж байгаа эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих хяналтыг Хууль сахиулах ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.”

**4 дүгээр зүйл.**Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн дугаарыг “9.6” гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн дугаарыг “9.5” гэж, мөн зүйлийн 9.4 дэх хэсгийн дугаарыг “9.6” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “Гүйцэтгэх ажилтан” гэснийг “Тагнуулын байгууллага гүйцэтгэх ажилтан, туслагч,” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “ажиллагаа болон тагнуулын байгууллагын харьяаллын гэмт хэргийг” гэснийг “ажиллагааг” гэж, 24 дүгээр

зүйлийн 24.1.1 дэх заалтад “9.2.1” гэснийг “9.4.1” гэж, “9.2.3” гэснийг “9.4.3” гэж, мөн зүйлийн 24.1.2 дахь заалтад “9.2.1” гэснийг “9.4.1” гэж, “9.2.3” гэснийг “9.4.3” гэж тус тус өөрчлөх.

**5 дугаар зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.7, 11.8 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.6 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4, 23.5, 23.6, 23.7, 23.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын .. өдөр

Улаанбаатар хот

### ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.7.гал түймэр гарсан тохиолдолд гал түймэр гарсан тухай акт тогтоох, эсхүл Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн 2.14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан тэмдэглэл хөтлөх;”

**2 дугаар зүйл.** Галын аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар  
сарын -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны хүрээнд:

1/эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны заавар;

2/эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны тактик, арга зүй, хүч хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж, орон тоо, зохион байгуулалт, баримт бичиг, архив, мэдээллийн сан, санхүүжилтийн тухай мэдээлэл.”

**2 дугаар зүйл.**Төрийн нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гүйцэтгэх ажилтай” гэсний өмнө “эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дугаарыг “6” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

**ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Дөрөв дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 45 дахь заалт нэмсүгэй:

45	Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны заавар, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар эрх бүхий байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, холбогдох баримт бичиг				+		60
----	--	--	--	--	---	--	----

**2 дугаар зүйл.**Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 6, 9 дэх заалт, Гурав дахь хэсгийн 35 дахь заалт, Дөрөв дэх хэсгийн гарчиг, мөн хэсгийн 39, 42, 46 дахь заалтын “гүйцэтгэх ажлын” гэсний өмнө, 42, 46 дахь заалтын “гүйцэтгэх ажил” гэсний өмнө “эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн Гурав дахь хэсгийн 35 дахь заалт, Дөрөв дэх хэсгийн 45, 47, 50, 51, 52 дахь заалтын “Гүйцэтгэх ажил” гэснийг “Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил” гэж, Дөрөв дэх хэсгийн 40, 41 дэх заалтын “Гүйцэтгэх ажлын” гэснийг “Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлын” гэж, 48 дахь заалтын “Гүйцэтгэх ажлын” гэснийг “Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны заавар, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон, эсхүл гүйцэтгэх ажлын” гэж, 1 дүгээр зүйлийн 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60 дахь заалтын дугаарыг “46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хууль сахиулах ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.